

ЭРДЭНЭХАЙРХАН УУЛЫН ДӨРВӨЛЖИН БУЛШНЫ СУДАЛГАА

Ц.ТӨРБАТ¹, Ч.ЕРӨӨЛ-ЭРДЭНЭ², С.ГУНЕРИ³

¹ШУА-ийн Археологийн хүрээлэн
e-mail: ts_turbat@yahoo.com

²ШУА-ийн Археологийн хүрээлэн
e-mail: cheruulerd@yahoo.com

³Туркийн Тогуз Ейлул их сургууль
e-mail: semihguneri@gmail.com

Түлхүүр үгс: Дөрвөлжин булш, Туулын хэлбэрийн булш, Эрдэнэхайрхан уул

ТОВЧ АГУУЛГА: Энэ өгүүлэлд Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Туул голын өмнөд эрэгт байх Эрдэнэхайрхан уулын хүрлийн үеийн оршуулгын газарт 2003 онд Монгол-Туркийн хамтарсан археологийн экспедицийн малтан судласан 8 булшны хэрэглэгдэхүүнийг нийтлэхийн зэрэгцээ уг дурсгалын олдворын судалгаа, оршуулгын зан үйлийн ажиглалт, он цагийн асуудлыг авч үзжээ. Малтлагаас шавар ваар савны том жижиг хэлтэрхий олон гарсан нь сонирхолтой олдворын тоонд орно.

Дурсгалын байрлал

2002 онд Эрдэнэхайрхан уулын дурсгалыг нээн олжээ. Уг дурсгал Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт, сумын төвөөс баруун тийш 73 км зайтай байх Эрдэнэхайрхан уулын ар, Бортолгой хэмээх жижиг толгойн ар бэлд бий. Газарзүйн байрлал нь ДТД 1093 м, N 47° 18' 30,8", E 105° 42' 28,6" болно.

Эрдэнэхайрхан уулын булшнууд нь голын урд эргийн хөндийд, уулын арын тэгш талд оршино. Энд нийтдээ хэлбэр төрхийн хувьд болон гадаад байдлын элэгдлийн хувьд ойролцоо 150 орчим булш бий юм. Тэдгээр нь тодорхой дэс дараа, зохион байгуулалтгүй хэд хэдээрээ бүлэглэж байрлажээ. Оршуулгын газрын доторх бүлгүүдийн хооронд булшны гадаад бүтцийн ялгаа ажиглагдахгүй байна. Булшнуудыг гадаад хэлбэрээр нь доорх хэдэн төрөлд ангилж болно.

1. Тэгш өнцөгт хавтгай чулуун дараастай,
2. Намхан тэгш өнцөгт хашлагатай дөрвөлжин дараастай,
3. Дугариг чулуун дараастай.

Булшнуудын хэмжээ харилцан адилгүй бөгөөд хамгийн жижиг нь 2×3 м байх бол хамгийн том нь 9×9,5 м хэмжээтэй байна. Дараасыг гол төлөв уулын хадны хэлтэрхийгээр нягт чигжиж хийжээ. Зарим булшны төв хэсэгт чулуу цөөтэй хонхорхой бий. Ихэнх булшнуудын дараас өргөргийн дагуу сунасан байрлалтай.

Зарим булшны гадаад хэлбэр дөрвөлжин булшнаас илүү хүннү булшийг санагдуулж байв. Юуны өмнө зарим булшинд огт хашлага байхгүй, дараас нь дугариг, дөрвөлжин бөгөөд намхан байх тул хүннүгийн жирийн иргэдийн булштай адил харагдаж байна. Өндөр чулуун хашлагатай, дөрвөн буландаа босоо чулуутай “сонгодог” дөрвөлжин булш энд огт байхгүй нь дээрх бодлыг улам гүнзгийрүүлж байлаа.

Судалсан тойм

2003 оны 5-р сард МУБИС-ийн Түүхийн салбарын багш оюутнууд хээрийн танилцах дадлагын үеэр энд 2 булш малтсан юм (Төрбат нар, 2003А). Мөн оны 8-р сард Монгол-Туркийн хамтарсан археологийн экспедиц энд дахин 8 булш малтжээ (Баттулга нар, 2004). Экспедицийн бүрэлдэхүүнд Монголын талаас МУИС-ийн Түрэг судлалын тэнхимийн эрхлэгч доктор Ц.Баттулга, МУБИС-ийн Монголын түүхийн тэнхмийн багш Ц.Төрбат, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ч.Ерөөл-Эрдэнэ, Туркийн талаас Измир хотын Тогуз Ейлул их сургуулийн багш доктор Семих Гунери нар оролцон ажиллажээ.


Эхний хоёр булшны хэрэглэгдэхүүнийг Ц.Төрбат хэвлүүлсэн байна (Төрбат, 2004: 5-12). Түүний малтсан хоёр булшны нэг нь огт оршуулга үгүй чулуун байгууламж байсан бол 2-р булш нь харин сайн хадгалагдсан хөндөгдөөгүй оршуулгатай байжээ. Булшнаас хүний хөндөгдөөгүй оршуулга илэрсэн төдийгүй ясан ба хүрэл зэв, хүрэл товчнууд гарсан байна. Тэрээр уг булшийг олдворын харьцуулалт ба радиокарбоны он цагийг баримтлан МЭӨ VII-IV зуунд хамаарна хэмээн он цагийг нь тогтоосон байна (Төрбат, 2004: 7). Түүнчлэн уг булшны гадаад хэлбэр байдал ба он цагийн баримжаа зэрэгт үндэслэн дөрвөлжин булшны соёлын он цагийн ялгаа бүхий хоёр үе шатны нэг “Туулын хэлбэрийн булш”-ны төлөөлөгч хэмээн үзсэн билээ.

Бид энэ өгүүлэлд Монгол-Туркийн хамтарсан археологийн экспедицийн малтан судалсан 8 булшны хэрэглэгдэхүүнийг нийтэлж байна.


Булшны тодорхойлолт

3-р булш. Оршуулгын газрын зүүн урд хэсэгт оршино. 5,4×5,1 м хэмжээтэй өргөргийн дагуу сунасан дөрвөлжин хэлбэрийн чулуун дараастай (Гар зураг 1). Жижиг, дунд хэмжээний чулууг битүү чигжиж байгуулжээ. Дараасны зүүн хэсэгт нэлээд том дөрвөлжин хэлбэрийн 3 чулууг цувуулан хашлага мэтээр босгон зоожээ. Дараасны хаяанаас 1 үе чулуу эхэлж төв хэсэгтээ 3 үе зузаантай болсон байна. 40 см гүнд өргөргийн дагуу сунасан зууван дугуй хэлбэртэй булшны нүх тодров. Нүхний хэмжээ 3×1,6 м. Нүхний төв хэсэгт хавтгай чулуунуудыг зулан тавьж таг хийсэн бололтой Үүний доор 55 см гүнд бүтэн араг яс бүхий оршуулга илрэв. Энд нэгэн хүнийг толгойгоор нь зүүн зүг харуулан, ар нуруугаар нь хэвтүүлж, хоёр гарыг их биеийн дагуу сунгаж, хөлийг жийлгэж тавьжээ. Мөчний төгсгөлийн (гарын атга, хөлийн тавхай) яснууд, мөн зарим хавирганы яс үгүй болсон. Аарцагны яс зэрэг

зарим яс хадгалалт муутай. Толгойн яс их биеэс салж дээш харан хэвтэж байсан бол эрүүний яс түүний урд талд саланги байна. Хүний толгойн доор чулуун дэр тавьж байсан бололтой (Гар зураг 2). Малтлагын явцад жижиг оюу сувс гарснаас өөр эд өлгийн зүйл илрээгүй.



Гар зураг 1. Эрдэнэхайрханы 3-р булшны дараасны дэвсгэр зураг, хөндлөн огтлол



Гар зураг 2. Эрдэнэхайрханы 3-р булшны малтлагын 1-р үе ба оршуулгын түвшин

4-р булш. Оршуулгын газрын төв хэсэгт хамгийн том дугуй дараастай булшны баруун урд талд оршино. 5×4 м хэмжээтэй баруун хойноос зүүн урагш чиглэлтэй сунасан тэгш өнцөгт хэлбэрийн чулуун дараастай. Дараасны төвд 3,1×2,6 м хэмжээний (гадуураа) тэгш өнцөгт чулуун хашлагатай. Хашлагыг уртлаг хавтгай

чулууг (60 см хүртэл өндөр) газарт хавиргалан зоож босгожээ (Гар зураг 3). Чулуун хашлаганы гадна болон дотор талд дунд жижиг хэмжээтэй чулууг 30-40 см гүнтэй чигжжээ. Булшны төв ба хойд хашлаганы орчмоос бор шарга өнгийн шавар савны хагархайнууд үргэлжлэн гарч байв. Эдгээр хагархайнуудыг эвлүүлж наахад нэгэн ваарны амсар болон бөөрний хэсгийн бараг хагас нь болж байна (Зураг 1). 80 см гүнд эх газар гарч малтлага дуусав.




Гар зураг 3. Эрдэнэхайрханы 4-р булшны дараасны дэвсгэр зураг

5-р булш. Оршуулгын газрын хойд хэсэгт оршино. 5×4,8 м хэмжээтэй, баруун урдаас зүүн урагш сунасан мэт тодорхой хэлбэргүй чулуун дараастай. Дараасны төв хэсэгт 60 см гүнд оршуулга илрэв. Энд жижиг яснууд нь үгүй болсон нэгэн араг яс байх бөгөөд хүнийг толгойгоор нь зүүн зүг хандуулан тэнэгэр байдлаар ар нуруугаар нь тавиад хоёр гарыг их биеийн дагуу сунган хөлийг жийлгэжээ. Гарын сарвууны зарим яс хадгалагдсан боловч нуруу, хавирганы яснууд ихэвчлэн үгүй болсон байна (Гар зураг 4). Хүний зүүн элгэн дээр бод малын далны ясыг тавьсан байна. Хүний гавлын яс хадгалалт муутай бөгөөд олон хэсэг болж хагарсан боловч бөөндөө байна.

6-р булш. Оршуулгын газрын зүүн урд хэсэгт 2,9×2,3 м хэмжээтэй өргөргийн дагуу сунасан тэгш өнцөгт хэлбэрийн чулуун дараастай (Гар зураг 5). Дараасны төв

хэсэгт чулуугүй хоосон зай байна. Үүний зүүн захад 60×25 см хэмжээтэй том чулууг хашлага мэтээр тавьжээ. Дараасыг аван 40 см малтахад эх газар гарч малтлага дуусав. Малтлагын явцад шавар савны хагархай олон тоотой гарч байв.




Гар зураг 4. Эрдэнэхайрханы 5-р булшны дараасны дэвсгэр зураг

7-р булш. Оршуулгын газрын зүүн урд хэсэгт бусдаасаа нэлээд зайтай сондгой оршино. Бусад булшийг уулын хадны хэлтэрхийгээр хийсэн бол энэ булшны дараасыг голын хайргаар хийжээ. 4 м голчтой ертөнцийн зүгүүд рүү булангаараа харсан дөрвөлжин хэлбэрийн дараастай (Гар зураг 6). Газар зүйн байрлал нь N 47°18'35", E 105°42'38,6", ДТД 1088 м. Дараасыг зайлуулж малтахад шууд эх хөрс гарч малтлагыг зогсоов.


8-р булш. Оршуулгын газрын зүүн урд хэсэгт оршино. Нягт чулуун чигжээстэй, тэгш өнцөгт хэлбэрийн дараастай булш. $4,9 \times 3,5$ м хэмжээтэй (Гар зураг 7). Чулуун дараасыг зайлуулж 40 см малтахад эх газрын хөрс гарч малтлага дуусав. Оршуулгагүй хоосон булш байжээ.




Гар зураг 5. Эрдэнэхайрханы 6-р булшны дараасны дэвсгэр зураг



Гар зураг 6. Эрдэнэхайрханы 7-р булшны дараасны дэвсгэр зураг



Гар зураг 7. Эрдэнэхайрханы 8-р булшны дараасны дэвсгэр зураг _



Гар зураг 8. Эрдэнэхайрханы 9-р булшны дараасны дэвсгэр зураг

9-р булш. Оршуулгын газрын хамгийн зүүн урд талд онцгойдуу оршино. Төвдөө чулуун хашлагатай тэгш өнцөгт хэлбэрийн дараас бүхий булш. 5,5×4,1 м хэмжээтэй (Гар зураг 8). Дараасны төвд байх хашлага хэдийгээр бүрэн биш боловч тэгш өнцөгт хэлбэртэй болох нь мэдэгдэнэ. Дараасыг зайлуулж доош малтах үед нүхний төв хэсэгт 50 см гүнээс шатсан модны хэлтэрхий, төмөр эдлэлийн үлдэгдэл илрэв.


10-р булш. Оршуулгын газрын баруун урд талд байрлах нэлээд том, дөрвөлжин дараастай булш. 9,5×9 м хэмжээтэй. Төвдөө чулуугүй хэсэг талбайтай. Энэ нь уг булш эрт цагт тоногдсон байж болохыг харуулна. Бид өөрсдийн хүч, цагийн бололцоог тооцож үзээд уг булшийг цэвэрлэсэн боловч гар зураг үйлдэж малталгүй орхив.

Олдворууд


Шавар сав. 4-р булш. Булшны нүхний төв хэсэг болон хойд ханын орчмоос хүрэн улаан өнгийн шавар савны олон тооны хэлтэрхий гарав. Эдгээрийг эвлүүлж үзэхэд 27,8 см голчтой шавар савны амсар, бөөрний бараг хагас эвлэж байв (Зураг 1). Зузаан нь амсар хэсэгтээ 1,1 см, бөөрний хэсэгтээ 0,8 см болно. Харин ваарны ёроолын хэсэг олдоогүй болно. Ваарын амсар нь дугуйрсан шөвгөр бөгөөд амсрын доогуур 7-10 шүдтэй багажаар 0,1 см өргөнтэй 45 хэмийн налуутай 0,5 см зайтай зэрэгцсэн олон зураасан хээг гаргажээ. Мөрний дагуу 1,3 см өргөн, 0,7 см өндөр хөндлөн хэрчмэл хээтэй товгор хүрээтэй. Товгор хүрээг хийхдээ урт бөөрөнхий бэлдцийг амсраас 3 см-ийн доор наагаад дээд, доод талаас нь 0,15 см орчим өргөнтэй 2 шүдтэй багажаар жигд дарж бэхэлсэн нь тодорхой харагдана. Товгорын дээгүүр 1,3 см орчим зайтайгаар 0,7 см урттай 3 шүдтэй дугуй үзүүртэй багажаар дарж хээлжээ. Товгорын дор 1 см зайд дотор талаас нь дугуй үзүүртэй зүйлээр шахаж товгор үрлэн хээ гаргасан ба үрлэн товгорууд 1,2 см голчтой (дотор талдаа 0,5 см голчтой), 0,3 см өндөртэй, хоорондоо 2,5 см зайтай байв. Ваарны гадна ханыг 4-5 шүдтэй багажаар самнаа хээ гаргаж чимэглэсэн бөгөөд босоо болон 45 хэм налуу дарж хээлсэн байна.

6-р булш. 1-р шавар сав. Малтлагын явцад булшны нүхний дунд хэсгээс хар хүрэн өнгийн шавар савны амсрын болон бөөрний хэлтэрхийнүүд гарав (Зураг 2, 3). Амсар нь хэвтээ дөрвөлжин хэлбэртэй. Амсрын доор 5-7 цуварсан шүдний мөртэй зураасан хээг 45 хэмийн налуутай гаргажээ. Амсрын доор 1,7 см-т, 0,6 см урттай босоо зураасаар 3 эгнээ чимэглэсэн байна. Түүний доор ханын гадна талаас 0,8 см голчтой дугариг үзүүртэй зүйлээр (модон буюу ясан багаж байж болно) хээлсэн байна. Шавар савны ёроол хэсэг олдоогүй. Зузаан нь амсар хэсэгтээ 1,1 см, бөөр хэсэгтээ 0,6-0,7 см болно.


2-р шавар сав. Мөн орчмоос хүрэн улаан өнгөтэй шавар савны амсрын хэлтэрхий олдсон байна. Уг савны амсар дотор талаас аажмаар налуу болоод гадна



Зураг 1. Эрдэнэхайрханы 4-р булинаас гарсан шавар ваар, гар зураг



Зураг 2. Эрдэнэхайрханы 6-р булинаас гарсан ваарны хэлтэрхийнүүд



Зураг 3. Эрдэнэхайрханы 6-р булинаас гарсан ваарны хэв хуулбар

талдаа эгц босоо байна. Уг савны хана чухам ямар хээ чимэглэлтэй байсныг хэлэх аргагүй юм.

Оюу сувс. 3-р булшнаас гарсан оюу сувс 0,5 см голчтой, нэвт нүх нь 0,1 см голчтой, 0,3-0,4 см өндөртэй болно.

Төмөр эдлэлийн үлдэгдэл. 9-р булшнаас гарсан төмөр эдлэлийн үлдэгдэл ихэд зэвэрч муудсан бөгөөд чухам ямар төрлийн эдлэл болохыг нь таних аргагүй юм. Бид уг зүйлийг төмөр хутганы хугархай байж болох юм хэмээн таамаглаж байна. Хос нүхтэй хоёр давхар нимгэн төмөр танигдах бөгөөд хутганы хуйны хэсэг байж болох талтай.

Олдворуудын харьцуулалт. Хэдийгээр бидний малтлагаар цөөн тооны олдвор илэрсэн боловч судалгааны өндөр ач холбогдолтой шавар савны хагархай гарсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. А.Д.Цыбиктаровын судалгаандаа хамруулсан Монгол ба Өвөр байгалийн 550 орчим булшны дотор зөвхөн 129 булш буюу 23,8%-иас нь шавар савны зүйл гарчээ (Цыбиктаров, 1998: 64). Тэдгээр нь ихэвчлэн чулуун дараасны дундаас илэрдэг тул оршуулгын дараах тахилгын ёслолын үед санамсаргүй байдлаар тэнд орсон бололтой байдаг. Зөвхөн 2 тохиолдолд шавар савны зүйл булшны нүхнээс гарсан байна. Үүнээс үзвэл ДБС-ын оршин суугчид нас барагчдаа шавар савны зүйл дагалдуулдаггүй зан үйлтэй байжээ гэж үзэж болно. Олдож буй шавар савны зүйлс үргэлж хэлтэрхий байдалтай гардаг. Иймээс тэдгээрийн талаар бүрэн төгс ойлголт авахад бэрхшээлтэй ажээ. Ямар боловч олдож буй шавар савны зүйлсийг: 1. Нарийн амсартай, 2. Задгай амсартай гэж ангилж болно. Шавар савны амсар дугариг болон хавтгай 2 янз байна. Ёроол нь хавтгай, болон гурван хөлтэй “хүлс” хэлбэрийн, цөөн зарим тохиолдолд өндгөн ёроолтой байдаг. Бүх савнуудыг гараар барьж хийсэн байна. Зарим нэгэн саванд туузан цувималын арга хэрэглэсэн нь ажиглагддаг. Савны гадаргыг гөлийлгөхөөс гадна сараачиж чимэглэсэн байдаг. Зарим савыг элдэв хээ болон нүх, төвгөр хүрээ зэргээр чимэглэсэн байдаг.

Эрдэнэхайрхан уулын булшнаас гарсан 3 төрлийн шавар савны зүйлс нь ДБС-ын шавар савтай ерөнхийдөө адил төстэй бөгөөд хийсэн арга технологи, хээлж чимэглэсэн байдал зэрэг нь эдгээр зүйлсийг хүрлийн үед холбогдохыг нь баттай заан өгч байна. Монголын дөрвөлжин булшнаас үүний өмнө ийм том хэмжээний хээ чимэглэлээр баялаг шавар савны зүйлс гарч байгаагүй тул Эрдэнэхайрханы 4 ба 6-р булшны шавар савууд судлаачдын анхаарлыг татах нь эргэлзээгүй билээ.

4-р булшны шавар савыг гараар барьж хийсэн бөгөөд харьцангуй нарийн ширхэгтэй зуурмагтай олон төрлийн чимэглэлийн аргыг хослуулан хэрэглэсэн сонирхолтой зүйл байна. Үүнтэй ижилсэх дурсгал Өвөрбайгалийн Чулуутын 7-р булшнаас гарсан байна (Цыбиктаров, 1998: Зураг 74).

6-р булшны шавар савыг мөн гараар барьж хийсэн бөгөөд илүү бүдүүн ширхэгтэй дүүргэгч хольц ихтэй зуурмагтай юм. Хээ чимэглэлийн хувьд ижилсэх

зүйл Өвөрбайгалийн Разъезд-71 дурсгалын 21-р булшнаас гарсан байна (Цыбиктаров, 1998: Зураг 77-3).

3-р булшнаас гарсан оюу сувс ДБС-ын хүрээнд өргөн тархсан олдворын нэг бөгөөд Монголын ба Өвөрбайгалын дөрвөлжин булшнаас олон тоогоор олддог. Үүний дотор Өвөрбайгалын Разъезд-71, Тологой, Бусыгино, Ононск, Малая Кулинда (Цыбиктаров, 1998: Зураг 40), Монголын Эгийн голын сав нутгийн Баянзүрх уул, Мухдагийн ам, Харуулын гозгор, Элст хөтөл, Эмгэнт хошуу зэрэг газрын дөрвөлжин булшнаас илэрчээ (Төрбат нар, 2003b, тал 47-48).

9-р булшнаас гарсан төмөр эдлэлтэй ижилсэх зүйл одоогоор дөрвөлжин булшны соёлын хүрээнд таарахгүй байгаа бөгөөд ер нь дөрвөлжин булшнаас төмөр эдлэл гарах нь туйлын ховор бөгөөд А.Д.Цыбиктаровын үзэж байгаагаар гарах үндэс ч байхгүй ажээ. Түүний тооцоолсноор нийт 7 булшнаас төмөр эдлэлийн хэлтэрхий олдсон бөгөөд тэдгээр нь бүгд булшинд санамсаргүй байдлаар орсон зүйлс байжээ.

Оршуулгын зан үйлийн зарим ажиглалт

Эрдэнэхайрханы оршуулгын газарт бид хоёр удаагийн судалгаагаар нийт 10 булш малтсан бөгөөд тэдгээрийн 3-аас нь оршуулга илэрчээ. Бусад булшинд (70%) ямар нэгэн оршуулга байсан шинж тэмдэг үгүй байлаа. Харин оршуулга бүхий булшнууд нь тоногдоогүй байх тул мэдээлэл сайтай юм. Оршуулгагүй хоосон дараас их хувийг эзлэж байх нь Эрдэнэхайрхан уулын оршуулгын газрын нэгэн онцлог шинж болно. Эдгээрийг чухам ямар зан үйлийн дагуу ингэж үйлдсэн болохыг одоогийн байдлаар тодорхойлох боломжгүй байна. Ямар боловч эдгээр хоосон булшнуудаас тахилга үйлдсэн ул мөр олдоогүй болохыг тэмдэглэе. Хүрлийн үеийн дөрвөлжин булшны соёлын хүрээнд нийт булшны 46,9%-иас хүний яс гараагүй боловч эдгээрийн нэлээд хэсэг нь эрт цагт тоногдсон булш болох юм.

Монгол болон Өвөрбайгалд малтсан 542 булшны 288-аас оршуулга илэрсэн бөгөөд зөвхөн 41 булшнаас хүний яс бараг бүтэн бөгөөд анатомийн байрлалаараа илэрчээ (Цыбиктаров, 1998: 45). Харин Эрдэнэхайрханы оршуулга бүхий 3 булшны хүний яс бүтэн буюу бараг бүтэн байна. Ер нь Эрдэнэхайрхан уулын булш шиг ийм бүтэн хөндөгдөөгүй араг яс маш ховор тохиолддог болохыг тэмдэглэе.

Булшинд хүнээ толгойгоор нь зүүн зүг хандуулан дээш харуулан тэнэгэр байдлаар тавьж хоёр гарыг их биеийг дагуулан сунгаж хоёр хөлийг жийлгэжээ.

Булшны дотор адуу малын яс болон эд өлгийн зүйлсийг тодорхой байрлалд тавьдаг байна. Юуны өмнө олонтоо тохиолдсон нэгэн зүйлийг дурдъя. Энэ нь оршуулга бүхий 3 булшнаас (1, 3, 5-р булш) гарсан чулуун дэр юм. Ийм чулуун дэр тавих заншил Монголын болон Өвөрбайгалын олон тооны дөрвөлжин булшнаас гарч байжээ (Наваан, 1975: 132). Д.Навааны бичсэнээр бол ийм заншил монгол, буриадуудын дунд байдаг ажээ. Монголын дөрвөлжин булшны дотор Н.Сэр-

Оджавын малтсан Шунхлай уулын булшнаас ийм чулуун дэр олонтоо гарч байсан болохыг тэмдэглэх нь зүйтэй (Эрдэнэбаатар, 2002: 193).

Өөр нэгэн зүйл бол хүний цээжин дээр болон хоёр хөлийн хооронд тавьдаг малын дал юм. 1-р булшинд бог малын дал хоёр хөлийн хооронд тавьсан бол 5-р булшинд хүний элгэн дээр бод малын далны яс тавьсан байжээ. Монголын дөрвөлжин булшинд ийм заншил мөн олонтоо тэмдэглэгдсэн болохыг Д.Наваан өгүүлжээ (Наваан, 1975: 134-135). Шунхлай уулын булшинд дал дагалдуулсан тохиолдол бараг булш болгонд байсныг (Эрдэнэбаатар, 2002: 193) тэмдэглэхийн хамт Эрдэнэхайрхан уулын дурсгал нь Шунхлай уулын булштай зан үйлийн хувьд хамгийн ойролцоо байгааг дурдъя. Мөн И.В.Асеевийн Богд сумын хуучин төвөөс баруун тийш 2 км-т 4 дөрвөлжин булш малтсанаас 2-р булшинд хүний оршуулга илэрсэн байна. Энэ хүний аарцган дээр хонины далны яс тавьсан байжээ (Асеев, 1985: 35).

Он цагийн хамаарал

Бидний мэдэлд буй хэрэглэгдэхүүнд баттай он цаг тогтоох зүйл үгүй юм. Зөвхөн 1-р булшнаас гарсан ясан зэв нэлээд хожуу үеийн хэв шинжтэй бөгөөд дийлэнх булшны гадаад хэлбэр нь дөрвөлжин булшнаас хүннү булшинд шилжих үеийн хэв шинжтэй байгааг үндэслэн бид Эрдэнэхайрхан уулын булшийг түрүү төмрийн үед холбогдох бололтой хэмээн үзэж байна.

Эрдэнэхайрхан уулын ойролцоо орших Морин толгойд Монгол-Солонгосын археологчдын малтсан дөрвөлжин булшнаас мөн хэрчмэл товгор бүслүүртэй шавар савны хэлтэрхий гарсан байна. Ийм хэлбэрийн шавар савыг А.Д.Цыбиктаров нэлээд өргөн хүрээнд хөгжингүй хүрлийн үеэс скифийн үед хамаарна хэмээн он цагийг нь тогтоосон байдаг (Цыбиктаров, 1998: 93).

2-р булшнаас гарсан хүний ясанд бид радиокарбоны анализыг БНСУ-ын Сөүлийн Их сургуулийн AMS лабораторид (SNU04-391) хийлгэсэнд одоогоос 2530 ± 120 жилийн өмнө буюу калибровк хийсний дараа МЭӨ 650 он (МЭӨ VII зуун) гэсэн он цагийг өгсөн юм (Төрбат, 2004: 7). Энэхүү радиокарбоны он цагийг үнэмлэхүй үнэн баттай зүйл гэж үзэхэд бэрхтэй ч олдворуудын харьцуулсан судалгааны дүнтэй зарим талаар нийцэж байна.

НОМ ЗҮЙ

Асеев И.В., 1985. К вопросу о датировке могил типа четырехугольных оградок. Древние культуры Монголии. Новосибирск..

Баттулга Ц., Төрбат Ц., Ерөөл-Эрдэнэ Ч., 2004. Эрдэнэхайрханы дурсгал: 2003 оны археологийн малтлага, судалгааны ажлын урьдчилсан тайлан. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан. УБ.

Наваан Д., 1975. Дорнод Монголын хүрлийн үе. УБ.

Төрбат Ц., 2004. Эрдэнэхайрхан уулын булш ба Дөрвөлжин булшны соёлыг үечлэх асуудалд. Acta Historica. Tom. V, Fasc. 1, УБ.

- Төрбат Ц., Энхчимэг Ц., Сүхбаатар На., 2003а.* МУБИС-ийн Түүхийн салбарын оюутнуудын 2003 оны хээрийн танилцах дадлагын тайлан. МУБИС. ТНУС. УБ.
- Төрбат Ц, Амартүвшин Ч., Эрдэнэбат У., 2003б.* Эгийн голын сав нутаг дахь археологийн дурсгалууд. УБ.
- Цыбиктаров А.Д., 1998.* Культура плиточных могил Монголии и Забайкалья. Улан-Удэ.
- Эрдэнэбаатар Д., 2002.* Монгол нутгийн дөрвөлжин булш, хиргисүүрийн соёл. УБ.

РЕЗЮМЕ

Ц.Төрбат, Ч.Ерөөл-Эрдэнэ, С.Гунери

ИЗУЧЕНИЕ ПЛИТОЧНЫХ МОГИЛ В ЭРДЭНЭХАЙРХАН-УУЛЕ

В данной статье приведены материалы раскопок совместной Монголо-Турецкой археологической экспедиции, проведенных в 2003 году на могильнике бронзового века, расположенном на территории Алтанбулаг сомона Центрального аймака, на южном берегу реки Тола. Авторы высказали свои предположения по поводу особенностей погребального обряда, внутримогильного инвентаря и хронологии изученных 8 захоронений. Здесь в большом количестве обнаружены глиняные черепки различных размеров, которые несомненно являются интересными находками.

В ходе раскопок не обнаружено предметов, по которым можно было бы установить точную дату сооружения данных могил. На основании конфигурации костяного наконечника стрелы из могилы № 1 и того, что их внешняя конструкция напоминает устройство захоронений переходного периода от плиточных могил к хуннским, мы предположительно датируем погребальные памятники горы Эрдэнэхайрхан началом железного века.